



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 378

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.4, 6.6 дахь заалт, 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын үндэсний музейн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 6,127,600.00 (зургаан сая нэг зуун хорин долоон мянга зургаан зуун) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий бүхий хавсралтад заасан автомашиныг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.
2. Монголын үндэсний музейн захирал Л.Жаргалд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:
  - 2.1. Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах, ашиглах ажлыг хууль тогтоомж, журмын дагуу Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;
  - 2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах,
  - 2.3. Акталж, данснаас хассан автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, тодорхойлолт, дээрх арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.
3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132007787

\Huraldaanii material\2021 он\2021.09.08 14-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 09 дүгээр сарын 62-ны өдрийн  
378 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ МУЗЕЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД  
БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ АВТОМАШИН

Д/д	Автомашины нэр, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн /ашиглалтад/ орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл
			/төгрөг/
1	Форд транзит, 2578 УНС, арал: VVF0EXXGBFE2R1191	2002/2001	6,127,600.00
НИЙТ ҮНЭ			6,127,600.00
			(зургаан сая нэг зуун хорин долоон мянга зургаан зуу)